



СОЁМБО МЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№81 /294/

2022.04.27

Цаг үе, үйл явдал

ТЭМЦЭЭНД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 33 НЭГТГЭЛ АНГИЙН 300 ГАРУЙ ТАМИРЧИД ОРОЛЦОЖ БАЙНА



Өнөөдөр таван толгой дах Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвд Цэрэгжлийн буудлага, саадын зурвас, мэргэн буудагчийн хоёр төрөлтийн тэмцээний нээлтүүд боллоо. Нээлтийн арга хэмжээнд ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга бригадын генерал С.Дашзэвэг, Сургалт бэлтгэлийн газрын ахлах мэргэжилтэн хурандаа Ш.Гантулга, Биеийн тамирын тасгийн дарга хурандаа Д.Цог-Эрдэнэ болон Зэвсэгт хүчний нэгтгэл ангийн захирагч, баг тамирчид оролцлоо. Өнөөдөр нээлтээ хийж байгаа цэрэгжлийн буудлага, саадын зурвас,

мэргэн буудагчийн хоёр төрөлтийн тэмцээнд Зэвсэгт хүчний 33 нэгтгэл ангийн 300 гаруй баг тамирчид оролцож байгаа юм.

Үүнээс гадна Зэвсэгт хүчний Марш-тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах тэмцээнд оролцохоор нутаг нутгаас 2000 гаруй дайчид цугларч, хэдий бэлтгэлдээ ороод байгаа юм. Нэг хэсэг нь гүйж байхад нөгөө хэсэг нь гарааны өмнөх ажиллагаандаа бэлтгээд, тал талд л завгүй залуус хэчнээн урамтай. Энэ жилийн Зэвсэгт хүчний Марш-тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах тэмцээн 5



дугаар сарын 3-10-ны өдрүүдэд болно. Үргэлжлүүлэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит Марш-тусгай бэлтгэлийн цогцолбор тэмцээн 5 дугаар сарын 20-24-ний өдрүүдэд болно.

Энэхүү тэмцээнд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчид оролцдоггоороо онцлог юм. Цэргийн

алба хаагчдын бие бялдрын бэлтгэлжилтийг хангах, тэсвэр хатуужил, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилготой энэхүү тэмцээн нь цэргийн мэргэжлийн онцлог, түүний ач холбогдлыг бие бүрэлдэхүүнд ойлгуулах, залуучуудыг бие бялдар, сэтгэл зүйн хувьд өв тэгш, аливаа бэрхшээлийг даван туулах чадвартай болгодог юм.



ЭНХИЙГ САХИУЛАГЧДАДАА ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЭ

Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, дэд хурандаа Б.Ууганбаярын гурван настай охин У.Маргад нь тархины үрэвсэл хэмээх хүнд өвчнөөр шаналсаар байна. Энэхүү бяцхан охиныг БНСУ-д яаралтай мэс засал хийлгэх эмч нарын зөвлөгөө, саналыг ирүүлсэн бөгөөд эмчилгээний зардалд 450 сая орчим төгрөг нэн шаардлагатай байгаа аж. Иймээс Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүнд хандаж, "Сайн үйлсийн аян"-д нэгдэх уриалгыг мөрдэс нэгт дайчин нөхөд нь гаргаад удаагүй байгаа юм.

Одоогоор Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн болон Тусгай хүчний цэргийн командлалын бие бүрэлдэхүүн нэг өдрийн цалингаа хандивласан талаарх мэдээлэл ЗХЖШ-ын Хэвлэл мэдээллийн албанд ирээд буй.

Дээрх уриалгыг дэмжин, БНСУ-д явагдаж байгаа НҮБ-ын энхийг сахиулах UNMISS ажиллагааны

11 дүгээр ээлжид үүргээ нэр төртэй гүйцэтгэж буй хурандаа О.Заяат захирагчтай Монгол Улсын Зэвсэгт хүчний мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүн 4250 ам.доллар хандивлажээ. Мөн мөрдэс нэгт офицерынхоо гэр бүлийг дэмжин, НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй 20 гаруй штабын ажилтан, ажиглагч офицеруудын зүгээс 5 сая 855 мянган төгрөгийг ирүүлээ.

Энэхүү цэнхэр дуулгалан-энхийг сахиулагчдаас ирүүлсэн мөнгөн тусламжийг ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга бригадын генерал С.Дашзэвэг өчигдөр дэд хурандаа Б.Ууганбаярт хүлээлгэн өглөө.

Ийнхүү уг "Сайн үйлсийн аян"-д нэгдэж, чин сэтгэлийн гараа сунгасан НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй цэнхэр дуулгатнууддаа талархал илэрхийлж, цаашдын албанд нь



улам их амжилтыг бэлгэдэн өрөөе.

Монголын нийт ард түмэн, түүний дотор Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний дунд аливаа өвчин эмгэгт шаналсан нэгэндээ сэтгэлийн ихээхэн дэм үзүүлж, тэдэнд амьдрал хайрласан бодит жишээ маш олон байна.

Тиймээс "Сайн үйлсийн аян" цаашид ч үргэлжилж байгаа бөгөөд "Тэнхлүүн явахад тэмээгээр тусалснаас Тэвдэж явахад тэвнээр тусал" хэмээх ардын үгийг бэлгэшээн, энэхүү аянд идэвхтэй хамрагдахыг Та бүхэнд дахин уриалж байна.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
9	-7

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	25

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,088.00	3,100.0
EUR	3,380.0	3,410.0
CNY	478.00	485.00
RUB	37.00	37.50
JPY	24.60	25.50
KRW	2.55	2.60

ЗУРХАЙ



2022.04.27 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 27/

ХАВРЫН АДАГ ХӨХ ЛУУ САРЫН ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ЦАГААН НОХОЙ ӨДӨР

Үс ЗАСУУЛБАЛ:
Өлзийтэй сайн
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.41-19.58
Барилдлага:
Үхэх
Шүтэн барилдлага:
Хуралцэхүй
Суудал: Төмөр

Энэ өдөр бар жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, лус тахиx, хүүхэд үрчлэн авах, гэр, байшингийн суурь тавихад сайн. Нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийх, цөөрөө байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өлзийтэй сайн.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН

2,272,84 /69.9%/

ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН

2,175,35 /66.9%/

ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН

1,037,670 31,9%
120,959 /3,7%/

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

8459 +112

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

9

ЭДГЭРСЭН

8321

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол


Нийт: 510,837,666

Эдгэрсэн

Нийт: 464,046,721

Нас барсан

Нийт: 6,249,012



Цахим шууданд

ЦЭРГИЙН ЭМЧ НАРЫН КОМИСС ОРОН НУТАГТ АЖИЛЛАЖ БАЙНА



Завхан аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб
Батлан хамгаалахын сайдын 2022 оны А/113 дугаар тушаалаар томилогдсон Цэргийн эмнэлгийн комиссын бүрэлдэхүүн батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу Завхан аймагт ажиллаа. Тайван цэгт цэргийн албанд тэнцэхгүй иргэдийн өвчин эмгэгийн байдалд дүгнэлт хийх энэ ажил нь Завхан нутгийн ард иргэдийг

эрүүлжүүлэх, тэр дунд цэргийн насны залуучуудыг эрүүлжүүлэх ажлын үр дүнд нөлөөлөх ач холбогдолтой арга хэмжээ болсон. Үзлэгт 200 гаруй иргэн хамрагдаж 70 орчим хувь нь тайван цагт цэргийн албанд тэнцэхгүй шийдвэрийг гаргуулж баталгаажуулав. Мөн энэ үеэр "Хугацаат цэргийн алба хаах насны иргэдийн эрүүл мэндийн байдалд

тулгарч буй бэрхшээл, түүнийг даван туулах арга зам, цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулах тухай" сэдэвт сургалтыг орон нутгийн эрүүл мэндийн салбарын удирдах бүрэлдэхүүнтэй явуулж харилцан санал солилцож, хамтын ажиллагааны үр дүнг сайжруулах чиглэлээр санал нэгдлээ.

Дэд хурандаа Г.БАВУУДОРЖ

АНГИЙН ТӨЛӨӨЛӨЛ ОРОЛЦОЖ ХҮРЭЛ МЕДАЛИЙН ЭЗЭН БОЛОВ



Зэвсэгт хүчний 325 дугаар анги
Монгол Улс энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тохиолдуулан Хил хамгаалах Ерөнхий газраас төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд сагсан бөмбөгийн аварга

шалгаруулах тэмцээнийг 4 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд 8 байгууллагын 16 шигшээ багийн тамирчид хурд хүч, авхаалж самбаага сорин өрсөлдсөнөөс эрэгтэйчүүдийн төрөлд тэргүүн байрт ОБЕГ, дэд байрт ЦЕГ, гутгаар байрт

Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний баг тамирчид эзэлсэн юм. Энэхүү тэмцээнд Зэвсэгт хүчний 325 дугаар ангийг төлөөлөн болох Д.Дүгэрсүрэн, дэд ахлагч Н.Батнасан амжилттай оролцож хүрэл медаль хүртсэн юм.

"МОНГОЛЫН БҮХ АРД ТҮМНИЙ XV ДУГААР СПАРТИКАДЫН АВАРГУУД ТОДОРЛОО"



Зэвсэгт хүчний 325 дугаар анги
Монголын бүх ард түмний XV дугаар спартикадын Улиастай хотын аварга шалгаруулах спортын цогцолбор тэмцээн 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр өндөрлөж шилдгүүдээ

шалгарууллаа. Тус тэмцээнд Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн баг тамирчид амжилттай оролцлоо. Тодруулбал, гар бөмбөгийн төрөлд эрэгтэй баг III дугаар байр, эмэгтэй баг I дүгээр байр, сагсан бөмбөгийн төрөлд эмэгтэй баг III дугаар байр, чөлөөт бөхийн 65кг жинд дэд ахлагч Г.Батсугар II дугаар байр, жудо бөхийн 74кг жинд дэд ахлагч Г.Нямдорж III дугаар байр, 81кг жинд ахлагч М.Мерейжан III дугаар байр, -100кг жинд ахлагч Г.Балжинням II дугаар байр, хүчний 3 төрөлтийн тэмцээнд ахлагч А.Мандалсүрэн суулт I дүгээр байр, таталт I дүгээр байр, цээж шахалт II дугаар байр, гурван төрлийн нийлбэрээр I дүгээр байруудыг тус тус эзэллээ.



"БАГШИЙН ХАНДЛАГА СУРАХ ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ НЬ" СЭДЭВТ НЭЭЛТТЭЙ ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Боловсролын Ерөнхий Газраас энэ сарын 22-ны өдөр их, дээд сургуулийн профессор багш нарын судалгаа, туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор зохион байгуулдаг "SCIENCE" цуврал цахим хэлэлцүүлгийг

Үндэсний батлан хамгаалах их сургуулийн Багшийн хөгжлийн төвтэй хамтран "Багшийн хандлага сурах үйлд нөлөөлөх нь" сэдвээр зохион байгууллаа. ҮБХИС-ийн Багшийн хөгжлийн төвийн дарга Г.Нандинцэцэг багшийн

хөгжлийн төвийн үйл ажиллагаа болон сургуулийнхаа багшийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар танилцуулга хийж, Цэргийн нэгдсэн дээд сургуулийн агаарын цэргийн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D), дэд хурандаа Ц.Дунгармаа Цэргийн холбоо кибер аюулгүй байдлын тэнхимийн ахлах багш, ахмад Н.Мөнх-эрдэнэ, Аюулгүй байдлын дээд сургуулийн нийгэм хүмүүнлэгийн тэнхимийн багш, доктор (Ph.D) Ц.Нарангэрэл, ҮБХИС-ийн Багшийн хөгжлийн төвийн сургалт, арга зүйн ахлах мэргэжилтэн, доктор (Ph.D) Д.Оюунбилэг нар сэдвийн хүрээнд илтгэл тавьж хэлэлцүүлэг өрнүүлээ.

Багшийн хөгжлийн төв

САМБО БӨХИЙН ЗАЛУУЧУУДЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД "АЛДАР"-ЫНХАН ТЭРГҮҮЛЭВ

Самбо бөхийн залуучуудын 2022 оны улсын аварга шалгаруулах тэмцээн 2022 оны 04 дүгээр сарын 21-23-ны хооронд Дархан-Уул аймгийн Дархан хотод зохион байгуулагдлаа. Уг тэмцээнд Зэвсэгт хүчний Алдар спорт хорооны Хошууч ОУХМ Д.Батсайхан дасгалжуулагчтай баг тамирчид оролцож 2 алт, 1 мөнгө, 3 хүрэл медаль тус тус хүртэж багийн дүнгээр тэргүүлээ. Тодруулбал, -54 кг-ийн жинд Х.Гал-Од-Алт, + 80 кг-ийн жинд Э.Жаргалмаа - Алт, -58 кг-ийн жинд Ө.Жанцандорж - мөнгө, -71 кг-ийн жинд Х.Өсөхбаяр - хүрэл, -88 кг-ийн жинд Н.Доржсамбуу - хүрэл, + 98 кг-ийн жинд Н.Нямжав - хүрэл медаль тус тус хүртлээ.



БИД БҮРЭЛДЭХҮҮН ОЛОН ТАЛЫН СУРГАЛТАД ХАМРАГДАВ



Зэвсэгт хүчний 186 дугаар анги
Ангийн бие бүрэлдэхүүний сургалтын цагаар Орхон аймгийн Тээврийн цагдаагийн албаны

байцаагч ахлах дэслэгч Д.Зоригтбаатар "Бага насны хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх" аяны хүрээнд "Жолоочийн үүрэг", Орхон аймгийн Улаан

загалмайн хорооны ажилтан Г.Цэлмэг, С.Наранчимэг нар "Эрүүл мэндийн анхан шатны тусламж" сэдвээр хичээл зохион байгуулж явууллаа.

Хошууч О.ОТГОНБААТАР

УРАН БҮТЭЭЛИЙН ТОГПОЛТ

Цянга төгөлдөр

Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн Номын санч МУСТА Амартөрийн ЛХАМХАНД

"Соёлын төв өргөө"-нд 2022.05.15-ны 15⁰⁰ цагт